

ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ МАЛТМАЛЫН ОЛБОРЛОЛТ, БОЛОВСРУУЛАЛТЫН ЦАЦРАГИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

1. Хамрах хүрээ ба зорилго

1.1. Хэвийн ашиглалтын үед болон ашиглалттай холбоотой үүсэж болзошгүй цацрагийн шарлагын тохиолдол, болзошгүй ослын нөхцөл байдалд цацрагийн шарлага үүсгэх боломжтой цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт, боловсруулалтын үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн байгууламжийг барих, ашиглах болон ашиглалтаас гаргах, түүнчлэн ашиглалтаас гаргасны дараа гарч болох цацрагийн эрсдлээс хүн ам болон байгаль орчныг хамгаалахад энэхүү дүрмийн зорилго оршино.

1.2. Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт, боловсруулалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд энэхүү дүрмийг “Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”, “Далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”, “Газрын дор хүчлээр уусган уран олборлоход мөрдөх техникийн зохицуулалт”, “Баяжуулах боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн нэгэн адил заавал дагаж мөрдөнө

1.3. Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт боловсруулалт, туршилтаас гарах хаягдалд “Хүдрийн болборлолт, боловсруулалтаас үүсэх хаягдлын хаягдлын менежментийн дүрэм”-ийн дагуу аюулгүй менежмент хийнэ.

2. Нэр томьёо

2.1. *Боломжит хамгийн сайн арга техник* гэдэг нь бүтээн байгуулалтын үйл ажиллагаа болон ашиглалтын аргачлалын хамгийн үр дүнтэй бөгөөд дэвшилтэт үе шатыг хэлэх бөгөөд энэ нь амьдралд хэрэгжүүлэхэд тохиромжтой болохыг нь илтгэнэ.

2.2. *Ашиглалтаас гаргах* гэдэг нь ажлын талбайг урт хугацаанд аюулгүй байлгахад шаардлагатай бүх үйл ажиллагаа, үүний дотор инженер техникийн эцсийн буюу бусад ажлыг гүйцэтгэж дуусгахыг хэлнэ.

“Ашиглалтаас гаргах” гэсэн нэр томьёог англи хэлээр цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийн хувьд “closure”, харин бусад байгууламжийн хувьд “decommissioning” гэж өөр өөрөөр оноосон байдаг. Тухайлбал ОУАЭА-ийн аюулгүй ажиллагааны толь бичигт (2007) дээрх нэр томьёонуудыг дараах байдлаар тодорхойлсон:

- *Closure: Цацраг идэвхт хаягдлыг хаягдал цуглуулах байгууламжид байрлуулсны дараа тодорхой хугацаанд бүх ажиллагааг дуусгах. Үүнд байгууламжийг удаан хугацаанд аюулгүй болгоход шаардлагатай инженер техникийн эцсийн буюу бусад ажил хамаарна.*
- *Decommissioning: Байгууламжийг (хаягдлын менежментийн байгууламжаас бусад) эрх бүхий зохицуулах байгууллагын хяналтаас хэсэгчлэн буюу бүхэлд нь чөлөөлөхөөр авсан захиргааны болон техникийн арга хэмжээнүүд.*

2.3. *Ашиглалтад авах* гэдэг нь баригдсан байгууламжийг ашиглалтад оруулж, зураг төслийн дагуу баригдсан эсэх, түүнчлэн шаардлагатай шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг нь шалгаж баталгаажуулах ажиллагааг хэлнэ.

2.4. *Барилга, угсралт* гэдэг нь байгууламжийн бүрэлдэхүүн хэсгүүдийн үйлдвэрлэл, угсралт, өрөмдлөг, уул уурхайн болон олон нийтийн барилгын ажил, бүрэлдэхүүн хэсэг болон тоног төхөөрөмжийн байгууламжийн ажлыг хэрэгжүүлэх, холбогдох сорилт, туршилт явуулах зэрэг ажиллагааг хэлнэ.

2.5. *Давхар хамгаалалт* гэдэг нь ашиглалтын үед үүсэж болзошгүй тохиолдлуудаас сэргийлэх, түүнчлэн ашиглалтын үед болон ослын нөхцөлүүдэд цацраг идэвхт материалыг хүн ам ба хүрээлэн байгаа орчноос тусгаарласан биет хамгаалалтын найдвартай байдлыг хангах янз бүрийн тоног төхөөрөмж болон горимын олон шатлалт тогтолцоог хэлнэ.

2.6. *Зураг төсөл* гэдэг нь байгууламж болон түүний хэсгүүдийн үндсэн санаа, дэлгэрэнгүй төлөвлөгөө, тооцоолол, техникийн үзүүлэлтийг боловсруулах ажиллагааг хэлнэ.

2.7. *Зураг төслийн үндэслэл* гэдэг нь тогтсон шалгуурын дагуу байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа төлөвлөсөн ашиглалтын дагуу зөвшөөрөгдсөн хязгаараас хэтрүүлээгүй нөхцөлд тухайн байгууламжийн даацыг илт харгалзан үзсэн хязгаарлах нөхцөл болон арга хэмжээг хэлнэ.

2.8. *Хаягдал цуглуулах* гэдэг нь *хаягдлыг* дахин ашиглахгүйгээр зохих ёсоор холбогдох хууль, дүрмийн дагуу хаягдлын менежментийн *байгууламжид* байрлуулахыг хэлнэ.

2.9. *Экстракцийн хаягдал* гэдэг нь цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, экстракци, боловсруулалт, хадгалалтаас шууд гарсан хаягдлыг хэлнэ. Үүнд (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) хаягдал чулуулаг, уурхайн хаягдал, ууршилтын үлдэгдэл, хэрэглэсэн ион солилцлын давирхай, ус цэвэршүүлэлтийн үлдэгдэл/тунадас лаг болон бусад хаягдал орж болно.

2.10. *Байгууламж* гэдэг нь цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт боловсруулалтын үйлдвэр болон ураны хүдрийн баяжмал үйлдвэрлэх үндсэн зорилготой аливаа байгууламжийг хэлэх бөгөөд үүнд технологийн үйл ажиллагаанд зориулсан аливаа байгууламж (газрын дор уусган олборлох, овоолгын уусган баяжуулалт, уулын ажил, бутлалт, хаягдал цуглуулах, хаягдал булшлах г.м.) хамаарна. Үүнд байгууламжийн барилга угсралт, ашиглалт, ашиглалтаас гаргахад шаардагдах агуулах, тоног төхөөрөмж, туслах барилга зэрэг туслах байгууламжууд орно.

2.14. *Онцлог, үйл явдал, үйл явц (FEP)* нь аюулгүй ажиллагааны үнэлгээ судалгаанд хамааралтай нөхцөл байдлыг тодорхойлоход хэрэглэдэг нэр томъёонууд юм:

- Онцлог нь байгууламжийн байрлаж буй ажлын талбайн онцлог шинж, жишээлбэл газрын гадарга, хөрсний ус, хөрс, агаар зэргийг тодорхойлно.
- Үйл явдал гэдэг нь зөвшөөрөл эзэмшигчийн урьдчилан тооцоогүй асуудал, үүний дотор ашиглалтын алдаа, тоног төхөөрөмжийн гэмтэл болон бусад осол эндэл, бусад этгээдийн санаатай үйлдэл, түүнчлэн цацрагийн аюулгүй ажиллагааны үүднээс хайхрамжгүй орхиж болохгүй үр дагавар болон болзошгүй үр дагаврыг хэлнэ.

- Үйл явц гэдэг нь байгууламжийн ажлын талбай дээр болон түүний ойр хавьд болж буй үзэгдэл, жишээлбэл хаягдал өгөршиж зөөгдөх, далд уурхай суух болон хүчил шүүрч ялгарах зэрэг үзэгдлийг хэлнэ.

2.15. Зэрэглэсэн хандлага гэдэг нь тухайн практик үйл ажиллагаа болон цацрагийн үүсгүүрийн шинж чанар болон шарлага, цацрагийн нөлөөллийн хэмжээ болон магадлалын онцлогт тохирсон аюулгүй ажиллагааны шаардлага хэрэгжүүлэхийг хэлнэ.

2.16. Тусгаарлалт гэдэг нь хаягдлыг байгалийн болон хүний гадны хүчин нөлөөллөөс хамгаалсан тогтолцоогоор хангахыг хэлнэ.

2.17. Зөвшөөрөл эзэмшигч гэдэг нь зөвшөөрөл дээр заасан байгууламж болон үйл ажиллагааг бүрэн хариуцах хуулийн этгээд болон хувь хүн эсвэл байгууллагыг (хариуцах байгууллага) хэлнэ.

Энэхүү дүрэмд зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахаас өмнө хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаар заасан үед зөвшөөрөл эзэмшигч гэсэн нэр томъёонд ирээдүйн зөвшөөрөл эзэмшигчийг [өргөдөл гаргагч] мөн хамруулна. Ийм тохиолдолд энэхүү дүрмийн заалтуудыг хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллага нь зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргахаас өмнө байгууламжийн үндсэн санааг боловсруулах үүрэгтэй байгууллага юм.

2.18. Удирдлагын тогтолцоо нь байгууллагын бүх бүрэлдэхүүн хэсгийг нэгдсэн нэг тогтолцоонд нэгтгэж, байгууллагын бүх зорилгыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг. Эдгээр бүрэлдэхүүн хэсэгт зохион байгуулалт, бүтэц, нөөц, горим ордог. Хүний нөөц, тоног төхөөрөмж, байгууллагын соёл, бодлогын баримт бичиг, горим нь удирдлагын тогтолцооны хэсгүүд юм.

2.19. Мониторинг, хяналт шалгалт, тандалт

Мониторинг гэдэг нь байгууламжаас хүн ам болон байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, байгууламжийн бүрэлдэхүүн хэсгийн төлөв байдлыг үнэлэхэд туслах байгаль орчны, инженер техникийн болон цацрагийн үзүүлэлтүүдийг тасралтгүй буюу тогтмол давтамжтайгаар ажиглаж, хэмжих ажиллагааг хэлнэ.

Хяналт шалгалт гэдэг нь барилга байгууламж, систем, бүрэлдэхүүн хэсгүүд болон материал, түүнчлэн ашиглалтын үйл ажиллагаа, техникийн горим, зохион байгуулалтын горим, журам, хүний нөөцийн чадавх зэргийг үнэлэхийн тулд хийдэг шалгалт, ажиглалт, хэмжилт буюу сорилт туршилтыг хэлнэ.

Тандалт гэдэг нь байгууламжийн ерөнхий ажиглалт, үүний дотор ашиглалтын үе шатны, шаардлагатай бол байгууламжийг ашиглалтаас гаргасны дараах мониторинг, сорилт туршилт, хяналт шалгалтыг хэлнэ.

2.20. Ашиглалтын хязгаарлалт ба нөхцөлүүд гэдэг нь зөвшөөрөгдсөн байгууламжийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор эрх бүхий хяналтын байгууллагаас баталсан үзүүлэлтийн хязгаарлалт, үйл ажиллагааны чадавх, үйлдвэрлэлийн горимын үзүүлэлтийн түвшинг тогтоосон багц шаардлагууд буюу дүрмийг хэлнэ.

2.21. *Ашиглалтаас гаргасны дараах* гэдэг нь инженер техникийн, хязгаарлалтын, тусгаарлалтын арга хэмжээнүүдийг авч, ашиглалтын барилга байгууламж болон туслах үйлчилгээг зогсоож, байгууламжийг эцсийн байдалд оруулсан үеэс эхлэх үе шатыг хэлнэ.

2.22. *Аюулгүй ажиллагаа* гэдэг нь хүн ам болон байгаль орчныг цацрагийн нөлөөллөөс хамгаалах үйлдлийг, мөн хэвийн ашиглалтын үед авч болох цацрагийн шарлага, ашиглалтын үед үүсч болзошгүй тохиолдлууд, мөн болзошгүй ослын тохиолдлуудыг сайтар тооцоолон хийгдэж байгаа төрөл бүрийн үе шатны ажлын явцад (барилга угсралт, ашиглалт, ашиглалтаас гаргах зэрэг) цацрагийн эрсдэл нэмэгдэхэд хүргэх тухайн үйл ажиллагаа болон байгууламжийн аюулгүй ажиллагааг хэлнэ.

2.23. *Ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагаа* гэдэг нь дунд буюу урт хугацаанд илэрч болох нөхцлүүдийн төрөл бүрийн боломжит хувилбаруудыг харгалзан үзсэний үндсэн дээр байгууламжийг ашиглалтаас гаргасны дараа хүн ам болон байгаль орчныг цацрагийн эрсдэлээс хамгаалах үйлдлийг хэлнэ.

2.24. *Аюулгүй ажиллагааны хөтөлбөр* гэдэг нь бүх үе шатанд байгууламжийн аюулгүй ажиллагааг дэмжих шинжлэх ухаан болон техникийн тайлбар, нотлох баримтын цуглуулгыг хэлнэ.

2.25. *Аюулгүй ажиллагааны үнэлгээ* гэдэг нь байгууламжийн аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийн талаар иж бүрэн дүн шинжилгээ хийж, аюулгүй ажиллагааны шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахыг хэлнэ.

2.26. *Аюулгүй ажиллагааны чиг үүрэг* гэж байгууламж ашиглалтад байх үед (ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны чиг үүрэг) ч тэр, байгууламжийг хаасны дараа (хаалтын дараах аюулгүй ажиллагааны чиг үүрэг) аюулгүй ажиллагааг хангах ёстой тусгай чиг үүргийг хэлнэ.

2.27. *Нөхцөл байдал* гэдэг нь түүхэн цаг хугацаанд болон ирээдүйд үүсч болзошгүй нөхцөл байдал руу хөтөлсөн онцлог, үйл явдал, үйл явц (FEP) болон/эсвэл нөхцлүүдийн урьдчилан таамагласан болон төсөөлсөн багц эсвэл дарааллыг хэлнэ.

Байгууламжийг ашиглалтаас гаргасны дараах ирээдүйн үйл явц болон төлөв байдлын хамрах хүрээг харуулах зорилгоор нөхцөл байдлын багцыг зохиодог. Эдгээр нь ямар таамаглалыг хэрэглэхэд тохиромжтой нь тодорхойгүй эсвэл энэ талын мэдлэг дутагдаж байгаа үед хэрэглэгдэж болно.

2.28. *Аюулгүй байдал* гэдэг нь ураны хүдрийн баяжмалтай холбоотой хулгай, хорлон сүйтгэх ажиллагаа, зөвшөөрөлгүй нэвтрэх, хууль бусаар шилжүүлэх буюу бусад санаатай үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах ажиллагааг хэлнэ.

2.29. *Ажлын талбай* (мөн *ажлын бүс* болон *үйл ажиллагааны талбай* гэнэ) гэдэг нь албан ёсны зөвшөөрөл бүхий байгууламж байрладаг газарзүйн бүсийг хэлнэ. Энэ нь зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс сэргийлэн биет хамгаалалтаар хүрээлэгдсэн байдаг бөгөөд үүний тусламжтай тухайн албан ёсны зөвшөөрөл бүхий байгууламжийн удирдлага эрх мэдлээ шууд хэрэгжүүлдэг.

2.30. *Ажлын талбайн судалгаа* гэдэг нь сонгосон ажлын талбай болон түүний орчин тойрон дахь газрын гадаргын болон газрын хэвлийн нарийвчилсан судалгаа, үйл ажиллагааг хэлнэ.

2.31. *Ажлын талбайн байгаль орчин* гэдэг нь байгууламжийн зүгээс байгаль орчин, хүний эрүүл мэнд, эд хөрөнгийн хувьд нөлөөлж болохуйц газарзүйн бүсийг хэлнэ. Үүнд газрын гадарга болон газрын хэвлий (жишээ нь: хөрсний ус) орно.

2.32. *Талбай сонгох* гэдэг нь байгууламжид тохиромжтой талбай сонгох явцыг хэлнэ. Байгууламжид тохирсон талбай сонгох явц нь ялангуяа ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагаанд чухал ач холбогдолтой. Тиймээс энэ арга хэмжээ нь маш удаан хугацаанд үргэлжилж болох бөгөөд дараах үе шатуудад хувааж болно: үндсэн санаа боловсруулах ба төлөвлөх, талбайн геодезийн зураглал, ажлын талбайн суурь судалгаа, талбайн баталгаажуулалт.

2.33. *Барилга байгууламж, систем, бүрэлдэхүүн хэсгүүд* гэдэг нь хүний хүчин зүйлээс бусад хамгаалалт, аюулгүй ажиллагаанд ач холбогдол бүхий байгууламж болон үйл ажиллагааны бүх элементийг (зүйл) хамарсан ерөнхий нэр томъёо юм.

2.34. *Туршилтын үйлдвэрлэл* гэдэг нь хязгаарлагдмал хугацаанд, бүрэн ашиглалтад орсон байгууламжгүйгээр, технологийн туршилтын зорилгоор ураны хүдрийн баяжмал болон завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг хэлнэ.

2.35. *Хаягдал* гэдэг нь цаашид ашиглахааргүй материалыг хэлнэ. Олборлолт болон бутлалтын үйл ажиллагаанаас үүссэн хаягдалд боловсруулалтын хаягдал, овоолгын уусган баяжуулалтын үлдэгдэл, хаягдал чулуулаг, тунадас, шүүлтүүрийн хатуурсан тунадас, хайрсан бүрхэвч (өрмөнцөр), янз бүрийн бохир ус орно.

2.36. *Цацраг идэвхт хаягдал* гэдэг нь эрх бүхий байгууллагаас тогтоосон чөлөөлөгдөх түвшнээс дээш идэвхтэй эсвэл агуулгатай цацраг идэвхт бодис агуулсан эсвэл ийм бодисоор бохирдсон хаягдлыг хэлнэ.

3. Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн зөвшөөрөл

4.1. Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалттай холбоотой үйл ажиллагаанд олгох Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн зөвшөөрөл нь дараах агуулгатай байх бөгөөд зөвшөөрлийн агуулгад тавигдах бусад шаардлагыг хангах ёстой. Үүнд:

- Батлагдсан аюулгүй ажиллагааны хөтөлбөр
- Батлагдсан ашиглалтын хязгаарлалт ба нөхцөлүүд
- Хүн амыг цацрагийн шарлагад өртүүлэх тунгийн хязгаарлалт.

4. Зөвшөөрөл хүссэн өргөдөл

3.1. Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасны дагуу олгосон цацраг идэвхт ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч Цөмийн энергийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалтыг хэрэгжүүлж,

доор дурдсан ажлуудыг эхлэхээс өмнө Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн зөвшөөрлийг хүсэж Хяналтын байгууллагад өргөдөл гаргана.

Үүнд:

- Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, судалгаа хийх
- Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт, боловсруулалтын барилга, байгууламжийн угсралт,
- Хаягдлын сангийн далан барих, хаягдлыг булшлах
- Ашиглалт эхлэх,
- Аюулгүй ажиллагаанд нөлөөлөхүйц өөрчлөлт хийх,
- Байгууламжийг ашиглалтаас гаргах; болон ашиглалтын дараа газар нөхөн сэргээх
- Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын зөвшөөрлийг дуусгавар болгох.

3.2. Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн зөвшөөрлийг авахад Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

- Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт, боловсруулалтын барилга, байгууламжийн угсралт угсралтын ажлаас өмнө зөвшөөрөлд өөрчлөлт оруулахыг хүсэж өргөдөл гаргахдаа:
 - барилга угсралтын ажлын цацрагийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр,
 - загварын үндэслэл,
 - санал болгосон ашиглалтын хязгаарлалт ба нөхцөлүүд,
 - ашиглалтаас гаргах ерөнхий төлөвлөгөө;
- ашиглалт эхлүүлэхээс өмнө зөвшөөрөлд өөрчлөлт оруулахыг хүсэж өргөдөл гаргахдаа:
 - ашиглалтын цацрагийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр,
 - санал болгосон ашиглалтын хязгаарлалт ба нөхцөлүүд,
 - ашиглалтаас гаргах ерөнхий төлөвлөгөө;
- ашиглалтаас гаргахдаа өмнө зөвшөөрөлд өөрчлөлт оруулахыг хүсэж өргөдөл гаргахдаа:
 - ашиглалтаас гаргах загварын үндэслэл,
 - ашиглалтаас гаргах эцсийн төлөвлөгөө,
 - ашиглалтаас гаргах цацрагийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр,
 - санал болгосон ашиглалтын хязгаарлалт ба нөхцөлүүд;
- байгууламжийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөхүйц өөрчлөлт хийхээс өмнө зөвшөөрөлд өөрчлөлт оруулахыг хүсэж өргөдөл гаргахдаа:
 - өөрчлөлт оруулсан аюулгүй ажиллагааны хөтөлбөр
 - ашиглалтын хязгаарлалт ба нөхцөлүүдэд өөрчлөлт оруулах саналын үндэслэл
- зөвшөөрлийг дуусгавар болгохыг хүсэж өргөдөл гаргахдаа:
 - зөвшөөрлийг дуусгавар болгох аюулгүй ажиллагааны хөтөлбөр

- ашиглалтаас гаргасны дараах мониторинг, тандалт судалгааны хөтөлбөр;

түүнчлэн эрх бүхий байгууллагаас хүссэн тохиолдолд аюулгүй ажиллагааны хөтөлбөрт дурдсан нэмэлт баримт бичгийг тус тус бүрдүүлнэ.

5. Зөвшөөрөл эзэмшигчийн ерөнхий үүрэг хариуцлага

5.1. Зөвшөөрөл эзэмшигч нь дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Эрх бүхий байгууллагаас олгосон холбогдох зөвшөөрөлгүйгээр туршилтын үйлдвэрлэл, барилга угсралт, ашиглалт, ашиглалтаас гаргах ажлыг эхлүүлэхгүй байх мөн байгууламжийг эзэнгүй орхихгүй байх,
- Зөвшөөрөл дуусгавар болох хүртэл байгууламжийн аюулгүй ажиллагааг баталгаажуулж, нотлох, түүнчлэн зөвшөөрөл дуусгавар болсны дараа ч гэсэн байгууламж аюулгүй хэвээр байна гэдгийг нотлох,
- Ялангуяа туршлага солилцох болон шинжлэх ухаан, технологийн ололт амжилтыг ашиглан аюулгүй ажиллагааг тасралтгүй дээшлүүлнэ,
- Үндэсний болон Олон улсын стандартад заасны дагуу аюулгүй ажиллагааны бодлогоо тогтоож хэрэгжүүлэх, аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлыг хамгийн түрүүнд анхаарах үүрэгтэй,
- Зөвшөөрөл дуусгавар болохоос өмнө ашиглалтаас гаргахад шаардагдах бүх үйл ажиллагааны нөөцийг хэрэгтэй үед нь ашиглахад бэлэн байлгах,
- Ашиглалтаас гаргасны дараа болон зөвшөөрөл дуусгавар болох хүртэл шаардлагатай нөхөн сэргээлтийн ажилтай холбоотой, мөн Аюулгүй ажиллагааны хөтөлбөрийн дагуу ажлын талбайд тандалт судалгаа хийхтэй холбоотой үүрэг хэвээр байна,
- Бүхийл үйл ажиллагаа, үүний дотор гэрээт гүйцэтгэгчдийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь зөвшөөрөл эзэмшигчийн удирдлагын тогтолцооны дагуу явагдаж, хяналтад байна.

5.2. Энэ дүрмийн дагуу олгосон зөвшөөрөл нь зөвшөөрөл эзэмшигчийг хууль эрх зүйн орчны хүрээнд шаардагдах бусад чиглэлийн хууль тогтоомжид заасны дагуу шаардагдах зөвшөөрөл болон зөвшөөрөл авах үүргээс чөлөөлөхгүй.

5.3. Зөвшөөрөл дуусгавар болсон бөгөөд зөвшөөрөл эзэмшигч хуулийн дагуу хүлээсэн бүх үүргээ биелүүлээгүй бол зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийн дагуу хүлээсэн үүргийнхээ төлөө хариуцлага хүлээсэн хэвээр үлдэнэ.

6. Хайгуул

6.1. Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн хайгуулын тусгай зөвшөөрөлтэй холбогдох хууль болон Цөмийн энергийн тухай хуульд заасан цацрагийн аюулгүй ажиллагаатай холбоотой бүх нөхцөл, Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул судалгааны цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм болон холбогдох бусад дүрэм журмын шаардлагыг дагаж мөрдөнө.

7. Удирдлагын тогтолцоо

7.1. Зөвшөөрөл эзэмшигч нь дараах зорилгоор удирдлагын тогтолцоогоо байгуулж, баримтжуулж, хэрэгжүүлж, үнэлж дүгнэн, тасралтгүй сайжруулах ёстой.

Үүнд:

- Эрүүл мэнд, байгаль орчин, аюулгүй байдал, чанар, эдийн засгийн шаардлагуудыг аюулгүй ажиллагааны шаардлагаас салгаж авч үзэхгүй байх,
- Байгууллагын бүх шатанд хувь хүн болон хамт олноороо аюулгүй ажиллагааг тууштай анхаардаг аюулгүй ажиллагааны соёлыг хэвшүүлж хөгжүүлэх
- Гүйцэтгэсэн ажил нь үе шат тус бүртээ батлагдсан аргачлал, заавар, зураг төсөл эсвэл бусад зохих журмын дагуу явагдсан гэдгийг батлах буюу тодорхой давтамжтайгаар хянагддаг байх,
- Удирдлагын тогтолцоонд хэвийн ашиглалтын нөхцлүүд, ашиглалтын үед үүсч болзошгүй тохиолдлууд, болзошгүй ослыг хамруулах,
- Удирдлагын тогтолцоонд байгууламжийн зураг төсөл, барилга угсралт, ашиглалтад авах, ашиглалт, ашиглалтаас гаргах болон ашиглалтаас гаргасны дараах үе шатны аюулгүй ажиллагааг анхаарах,
- Удирдлагын тогтолцоог байнгын үр дүнтэй байлгахын тулд тогтмол хугацаатай хянах,

7.2. Зөвшөөрөл эзэмшигч нь удирдлагын тогтолцоонд наад зах нь дараах зүйлсийг баримтжуулах ёстой. Үүнд:

- Аюулгүй ажиллагааны бодлого,
- Зохион байгуулалт, бүтцийн тодорхойлолт,
- Чиг үүрэг, хариуцлага, эрх мэдлийн түвшин, ажлыг удирдаж, гүйцэтгэж, үнэлж буй хүмүүсийн харилцааны тодорхойлолт,
- Зөвшөөрөл эзэмшигчийн гэрээт гүйцэтгэгчидтэй харилцах харилцаа, үүний дотор гэрээт гүйцэтгэгчдийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тавих хяналтын тодорхойлолт,
- Ажлыг хэрхэн бэлтгэх, хэрэгжүүлэх, бүртгэх, үнэлэх, хянах, сайжруулахыг тайлбарласан нэмэлт мэдээлэл болон ажлын аргачлалын тухай тайлбар,
- Байгууламжийн аюулгүй ажиллагаатай холбоотой бүх талын тухай мэдлэг, мэдээлэл, өгөгдлийг бүртгэж, хянах, бүртгэлийг хадгалах заалтуудын тодорхойлолт,
- Зөвшөөрөл дуусгавар болох хүртэл янз бүрийн үе шатад ажилтнуудад мэдлэгийг зохистой дамжуулах тухай заасан заалтуудын тодорхойлолт,
- Ашиглалтын туршлага ба санал солилцох зэрэг болно.

7.3. *Байгууллагын цацрагийн удирдлагын хөтөлбөрийг боловсруулахад “Цацраг идэвхт ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаанд баримтлах цацрагийн удирдлагын хөтөлбөр боловсруулах зөвлөмж”-ийг ашиглана.*

8. Бүртгэл хөтлөлт ба мэдлэгийн хадгалалт

8.1. Зөвшөөрөл эзэмшигч нь зураг төсөл [хэрэв зөвшөөрөл олгогдоогүй байгаа бол зөвшөөрөл хүсэгч], барилга угсралт, ашиглалтад авах, ашиглалт, ашиглалтаас

гаргах болон ашиглалтаас гаргасны дараах үе шатад аюулгүй ажиллагаанд чухал ач холбогдолтой мэдлэг, бүртгэлийг зөвшөөрөл дуусгавар болтол бэлэн байлгаж, шинэчилсэн байх ёстой. Үүнд аюулгүй ажиллагааны үнэлгээ болон урт хугацааны бүртгэл, ялангуяа дараах зүйлстэй холбоотой мэдлэг, бүртгэл орно. Үүнд:

- Ажлын талбайн онцлог шинж,
- Зураг төслийн үндэслэл,
- Зураг төсөл,
- Байгууламжийн барилга угсралтын явц болон түүний өөрчлөлт,
- Ашиглалтын түүх, үүний дотор ашиглалтын үед үүссэн тохиолдлууд болон ослоуд,
- Ураны хүдрийн баяжмалын бүртгэл тооцоо,
- Ионжуулагч цацрагт хүн ам болон байгаль орчны өртөх шарлага,
- Үүсэн гарсан цацраг идэвхт хаягдлын тоо бүртгэл,
- Ашиглалтаас гаргасны дараах хаягдал цуглуулах тогтолцооны төлөв байдал;

8.2. Зөвшөөрөл дуусгавар болоход ажлын талбай болон байгууламжийг ашиглалтаас гаргасан тухай бүртгэл мэдээллийг үндэсний хууль, эрх зүйн хүрээнд урт хугацаанд тасралтгүй хянаж, хэрэглэхэд боломжтой байлгана.

9. Зохион байгуулалт, бүтэц, хүний нөөц, сургалт

9.1. Зөвшөөрөл эзэмшигч нь:

- Аюулгүй ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэхдээ үүрэг хариуцлага, эрх мэдлийн хүрээ, холбоо харилцааг маш ойлгомжтой байлгах зохион байгуулалт, бүтцийг бий болгож, баримтжуулсан байх ёстой,
- Холбогдох бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг чадварыг бий болгож, хадгалахын тулд хүний нөөц, ур чадвар, туршлага, мэдлэгийн нөөц бололцоогоо тодорхойлон баримтжуулж, зохион байгуулалтаа ирээдүйн төлөвлөгөөнийхөө дагуу цаг алдалгүй зохион байгуулан өөрчилж байх ёстой,
- Аюулгүй ажиллагаанд нөлөөлж болох үйл ажиллагаанд оролцож буй бүх ажилтанд тавигдах мэргэжлийн мэдлэг, туршлага, ур чадварын шаардлагыг тодорхойлно,
- Ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг хөгжүүлж, хадгалахын тулд, мөн үйл ажиллагаа тус бүрийг эхлэхээс өмнө ажилтнуудыг зохих түвшинд сургаж бэлтгэсэн гэдгийг баталгаажуулах сургалтын хөтөлбөрийг бий болгон, баримтжуулах ёстой,
- Байгууллагын хүрээнд, аюулгүй ажиллагаа болон бүтээгдэхүүний чанарыг хангахад гэрээт гүйцэтгэгчийн нөөц бололцоо, ур чадвар, дүрэм журам хангалттай эсэхийг үнэлэх чадавхтай байх ёстой.

10. Байгууламжид тавигдах ерөнхий шаардлагууд

10.1. Зөвшөөрөл эзэмшигч нь доорх шаардлагуудыг биелүүлэх ёстой. Үүнд:

- цацрагийн хамгаалалтын шалгуур зарчим, тухайлбал шарлагын тунг аль болох бага байлгах (ALARA) зарчмын дагуу хүн ам болон байгаль орчныг хамгаалах үүднээс байгууламжийн зураг төслийг [хэрэв зөвшөөрөл олгогдоогүй байгаа бол зөвшөөрөл хүсэгч] зохиож, барилга угсралт, ашиглалтыг хэрэгжүүлж, ашиглалтаас гаргаж, ашиглалтаас гаргасны дараах тандалт судалгаа явуулах,

- байгууламжийг ашиглалтаас гаргасны дараа болон түүний дараа тодорхой хугацаанд хийгдэх байгууллагын идэвхгүй буюу маш бага идэвхтэй хяналтын аргаар аюулгүй байдал хангагдана гэдгийг батлах,
- байгууламжийн бүтээн байгуулалт, ашиглалтын болон ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргасны дараах үе шатуудын турш аюулгүй ажиллагаа оновчтой түвшинд хэрэгжсэн гэдгийг батлах,
- байгууламжаас ялгарах хаягдлыг цуглуулах тогтолцоо нь хэвийн хувьсал өөрчлөлтийн нөхцөлд тусгаарлах болон хязгаарлах үүргээ хангаж чадна гэдгийг баталгаажуулж, хаягдал цуглуулах ажиллагаа нь шаардлагатай хугацааны турш тусгаарлах болон хязгаарлах боломжоор найдвартай хангана гэдгийг тогтоох,
- Аюулгүй ажиллагааны хөтөлбөрийн шаардлагыг хангахуйц байгууламжийн хувьсал өөрчлөлтийн талаар ойлголт өгөх зорилгоор тохиромжтой хөтөлбөрийг тодорхойлж, хэрэгжүүлнэ (жишээ нь: судалгаа, загварчлал, сорилт, мониторингийн үйл ажиллагаанууд),
- барилга угсралт, ашиглалт буюу ашиглалтаас гаргах үйл ажиллагаа зэрэг явагдах тохиолдолд хийгдэх ажлууд нь ашиглалтын буюу ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагаанд зөвшөөрөгдөхгүй нөлөөлөл үзүүлэхгүй байхад анхаарна.

11. Ажлын талбайн тодорхойлолт

11.1. Зөвшөөрөл эзэмшигч [үүний дотор хэрэв зөвшөөрөл олгогдоогүй байгаа бол зөвшөөрөл хүсэгч] дараах зорилгоор сонгосон ажлын талбайг судалж тодорхойлох хөтөлбөр бэлтгэж, баримтжуулж, хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хамгийн багадаа бүтэн жилийн ажиглалтын хугацаанд, эрх бүхий байгууллага шаардвал хоёр хүртэл жилийн хугацаанд барилга угсралтын өмнөх буюу уурхайн бүтээн байгуулалтын өмнөх ажлын талбай болон байгаль орчны суурь нөхцлүүдийг тогтоох,
- Байгууламжийн хэвийн хувьсал өөрчлөлтийн нөхцлүүдийн талаарх ойлголтыг сайжруулах,
- Ажлын талбай болон байгууламжтай холбоотой нөхцөл байдлыг алдагдуулж болзошгүй үйл явдал болон тэдгээрийн явцын талаар илүү тодорхой болгох,
- Аливаа онцлог, үйл явдал болон үйл явцын аюулгүй ажиллагаанд учруулах нөлөөллийн тухай ойлголтыг сайжруулах зэрэг багтана.

12. Зураг төсөл

12.1. Зөвшөөрөл эзэмшигч [хэрэв зөвшөөрөл олгогдоогүй байгаа бол зөвшөөрөл хүсэгч] нь холбогдох багц онцлог, үйл явдал, үйл явцаас үүдэлтэй хэвийн ашиглалтын нөхцлүүд, ашиглалтын үед үүсч болзошгүй тохиолдлууд, болзошгүй ослын тохиолдлуудыг харгалзан байгууламжийн зураг төслийн үндэслэлийг тогтоож, баримтжуулах ёстой;

12.2. Зөвшөөрөл эзэмшигч [хэрэв зөвшөөрөл олгогдоогүй байгаа бол зөвшөөрөл хүсэгч] нь байгууламжийн зураг төслийг дараах нөхцөлүүдийг хангахуйц гаргах ёстой. Үүнд:

- Сонгосон ажлын талбайн техник технологийн боломжуудын үндэслэл болон онцлог шинжүүдийг харгалзсан, ашиглалтаас гаргасны дараах

байгууламжийн хэвийн хувьсал өөрчлөлтийн нөхцөлүүд болон ашиглалтаас гаргасны дараах байгууламжийн хэвийн хувьсал өөрчлөлтийн нөхцөл байдлыг алдагдуулж болох үйл явдал болон тэдгээрийн явцыг харгалзсан, түүнчлэн хаягдлын менежментийн байгууламжийн хувьд цуглуулах хаягдлын онцлог шинжийг харгалзсан ашиглалтын үеийн болон ашиглалтаас гаргасны дараах ажлын талбайн аюулгүй ажиллагаа болон нөхөн сэргээлт,

- Ашиглалт болон ашиглалтаас гаргасны дараах үе шатанд хүн ам болон байгаль орчны шарлагыг хянах, цацраг идэвхт материалыг тусгаарлах,
- Инженер техникийн шийдэлтэй бүрэлдэхүүн хэсгүүд нь цуглуулах хаягдал болон түүнийг агуулагч байгаль орчинтой, түүнчлэн өөр хоорондоо физик, химийн хувьд хангалттай түвшинд нийцтэй байх,
- Аюулгүй ажиллагаанд чухал ач холбогдолтой барилга байгууламж, системийн засвар үйлчилгээ, сорилт, хяналт шалгалт, мониторинг хийх нөхцөлөөр хангагдсан,
- Эх үүсвэр болон байгаль орчны хяналтад зориулсан хангалтыг бэлэн байлгах,
- Цацрагийн хамгаалалтыг хангах, засвар үйлчилгээ болон хяналт шалгалт хийхэд дөхөм болгох, ашиглалтын үед үүсч болзошгүй тохиолдлууд, болзошгүй ослын тохиолдлууд үүсэх магадлал болон үр дагаврыг аль болох багасгахад чиглэсэн тоног төхөөрөмжүүдийг байгууламж дээр бэлэн байлгах.

13. Мэдээлэл цуглуулах ба мониторинг

13.1. Зөвшөөрөл эзэмшигч нь туршилтын үйлдвэрлэл буюу барилга угсралтыг эхлүүлэхээс өмнө цацрагийн хяналтын хөтөлбөрийг дэмжих, түүнчлэн байгууламжийн хүн ам, байгаль орчинд үзүүлэх цацрагийн нөлөөллийг үнэлэх зорилгоор байгаль орчны суурь судалгаа хийж, баримтжуулна.

13.2. Зөвшөөрөл эзэмшигч нь барилга угсралтыг эхлүүлэхээс өмнө барилга угсралт, ашиглалтад авах, ашиглалт, ашиглалтаас гаргах болон шаардлагатай бол ашиглалтаас гаргасны дараах үе шатанд хэрэгжүүлэх системтэй мониторингийн хөтөлбөрийг тодорхойлж, нэмэлт өөрчлөлт оруулж, баримтжуулна;

13.3. Зөвшөөрөл эзэмшигч нь мониторингийн хөтөлбөрт дараах зүйлүүдийг анхаарвал зохино. Үүнд:

- Хүн ам, байгаль орчныг хамгаалах,
- Хууль дүрмийн шаардлага, зөвшөөрлийн нөхцөлүүдийг хэрэгжүүлж байгаагаа нотлон харуулах,
- Байгууламж нь Аюулгүй ажиллагааны хөтөлбөртэй нийцэж сайн ажиллаж, боловсронгуй болж байгааг баталгаажуулах,
- Байгаль орчны нөхцөлүүд болон байгууламжийн ажиллагааны талаар ойлголт өгөх,
- Мониторингийн хөтөлбөртэй холбоотой, түүнчлэн ашиглалтын тохиолдлууд болон ослын үеийн байдалтай холбоотой гаргах шийдвэрийг дэмжих мэдээлэл олж авах,
- Ашиглалтаас гаргасны дараах мониторинг болон тандалт судалгааны хөтөлбөрт зориулсан суурь мэдээллээр хангах,
- Тунгийн үнэлгээ хийх.

13.4. *Байгууллагын цацрагийн дотоод хяналт, шинжилгээний төлөвлөгөөг боловсруулахад “Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт, боловсруулалтын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын цацрагийн дотоод хяналт, шинжилгээний төлөвлөгөө боловсруулах зөвлөмж”-ийг ашиглана.*

14. Аюулгүй ажиллагааны үнэлгээ

14.1. Зөвшөөрөл эзэмшигч нь барилга угсралт, ашиглалт, ашиглалтаас гаргах болон ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагааны үнэлгээ хийж, баримтжуулах ёстой. Үүнд:

- Барилга угсралт, ашиглалтын, ашиглалтаас гаргах үеийн аюулгүй ажиллагааны үнэлгээ хийхдээ дараах зүйлсийг авч үзсэн байх ёстой. Үүнд: хэвийн ашиглалт, ашиглалтын үед үүсч болзошгүй тохиолдлууд, болзошгүй ослоос үүдэлтэй мэргэжлийн шарлага болон хүн амын шарлага,
- Ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагааны үнэлгээнд дараах зүйлийг харгалзан үзсэн байх ёстой. Үүнд: хаягдал цуглуулах тогтолцооны ажиллагаанд нөлөөлж болзошгүй онцлог, үйл явдал болон үйл явцыг тооцсон нөхцөл байдлын дүн шинжилгээ,

14.2. Аюулгүй ажиллагааны үнэлгээндээ зөвшөөрөл эзэмшигч [хэрэв зөвшөөрөл олгогдоогүй байгаа бол зөвшөөрөл хүсэгч] нь хүн ам буюу байгаль орчинд хор уршиг тарихаас өмнө давах буюу тойрч гарах ёстой хэд хэдэн давхар хамгаалалтын үеүдийг (жишээ нь: биет хамгаалалт, хамгаалалтыг хамгаалах систем, захиргааны ажиллагаа) нэгтгэсэн давхар хамгаалалт хангалттай эсэхийг тогтоох ёстой. Зөвшөөрөл эзэмшигч [хэрэв зөвшөөрөл олгогдоогүй байгаа бол зөвшөөрөл хүсэгч] Аюулгүй ажиллагааны хөтөлбөрт аюулгүй ажиллагааны үнэлгээ хийх хугацааг тодорхойлж, үндэслэлийг нь гаргах ёстой.

15. Аюулгүй ажиллагааны хөтөлбөр

15.1. Зөвшөөрөл эзэмшигч [хэрэв зөвшөөрөл олгогдоогүй байгаа бол зөвшөөрөл хүсэгч] нь дараах үндэслэлүүдийг хангахын тулд байгууламжийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, баримтжуулж, нэмэлт өөрчлөлт оруулах ёстой. Үүнд:

- Ашиглалт, ашиглалтаас гаргах болон ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагааны шаардлагуудыг, ялангуяа ажилчид, олон нийт, байгаль орчны аюулгүй байдлыг хангаж байгааг эсэх,
- Зураг төсөл, барилга угсралт, ашиглалт, ашиглалтаас гаргах болон ашиглалтаас гаргасны дараах үйл ажиллагаа, үүний дотор байгаль орчны нөлөөтэй холбоотой үйл ажиллагааны техникийн үндэслэлийн үнэлгээг шилдэг туршлагын дагуу гүйцэтгэсэн эсэх,
- Ашиглалт, ашиглалтаас гаргах болон ашиглалтаас гаргасны дараах үе шатны аюулгүй ажиллагааны үнэлгээ, үүний дотор цацрагийн нөлөөллийн хувьд байгууламж болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн ажиллагаа болон ашиглалтын найдвартай байдлыг үнэлсэн үнэлгээг харгалзан үзсэн байх,
- Ирээдүйд тохиолдох хүний хүчин зүйл, үүний дотор хүн амын суурьшил нэмэгдэх нөхцлийг харгалзан үзсэн байх,
- Аюулгүй ажиллагаа болон түүний ач холбогдолд нөлөөлөх хүчин зүйлсийг (жишээ нь: онцлог, үйл явдал, үйл явц) хангалттай сонгосон байх,
- Бүх тодорхойгүй байдлыг хангалттай тооцсон байх,
- Зэрэглэсэн хандлагыг хэрэгжүүлсэн байх,

- Аюулгүй ажиллагааны хөтөлбөр болон нэмэлт баримт бичгийн өөрчлөлтүүдийг хянах боломжоор хангасан байх,
- Нэмэлт баримт бичиг болон хэвлэмэл материалыг зохих ёсоор эшэлсэн байх;

15.2. Аюулгүй ажиллагааны хөтөлбөрт юуны өмнө энэ дүрэм дээр үндэслэн боловсруулсан баримт бичгийн үндсэн мэдээллийг багтаах бөгөөд дараах агуулгатай байна:

1. Оршил
2. Ерөнхий мэдээлэл
3. Удирдлагын тогтолцоо
4. Ажлын талбай ба байгаль орчин
5. Байгууламжийн тодорхойлолт
6. Аюулгүй ажиллагааны үнэлгээ
7. Ердийн нөхцөлд агаар дахь цацраг идэвхт хаягдал байгууламжаас гадагшлах байдал
8. Ердийн нөхцөлд шингэн цацраг идэвхт хаягдал байгууламжаас гадагшлах байдал
9. Байгууламжаас гарах цацраг идэвхт хатуу хаягдал цуглуулах
10. Ашиглалтын хязгаарлалт ба нөхцөлүүд
11. Ажилчдыг цацрагаас хамгаалах
12. Цацраг идэвхт хаягдлын төлөвлөгдөөгүй алдагдал
13. Ажлын талбай дээрх болон ажлын талбайн гадна болзошгүй ослын үеийн төлөвлөгөө
14. Мониторинг
15. Аюулгүй байдал
16. Хянаж, шинэчлэх

15.3. Аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахад “Цацраг идэвхт ашигт малтмалын олборлол, боловсруулалтын цацрагийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр боловсруулах зөвлөмж”-ийг ашиглана.

15.4. Цацраг идэвхт хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулахад “Цацраг идэвхт ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагааны хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмж”-ийг ашиглана.

16. Барилга угсралт

16.1. Зөвшөөрөл эзэмшигч нь байгууламжийг барихдаа дараах нөхцөлүүдийг хангасан байх ёстой. Үүнд:

- Зөвшөөрөл, зураг төсөл, аюулгүй ажиллагааны хөтөлбөрийн дагуу, боломжтой хамгийн сайн арга техникийг хэрэглэх,
- Ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагааны чиг үүргийг хадгалахуйц байхаар;

16.2. Зөвшөөрөл эзэмшигч нь дараах зүйлсийг үнэлэхийн тулд барилга угсралтын явцад мониторинг, тандалт судалгаа явуулж мэдээлэл бүрдүүлнэ. Үүнд:

- Хүн ам, гадаад орчны шарлага,
- Тухайн орчны бодит шинж чанар,
- Тухайн орчны байгууламжид үзүүлэх хариу үйлдэл;

16.3. Зөвшөөрөл эзэмшигч нь зураг төсөл, барилга угсралтын явц, аргачлалын ямар нэгэн өөрчлөлтийг төлөвлөж, үнэлж, баримтжуулж, хэрэгжүүлэхдээ тухайн өөрчлөлтийн зүгээс аюулгүй ажиллагааны ач холбогдолд нийцэх зохицуулалтыг ашиглана. Эдгээр зохицуулалт нь тухайн өөрчлөлтүүд ашиглалтын болон ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагаанд үл зөвшөөрөгдөх нөлөөлөл үзүүлэхгүй байх явдлыг хангана.

16.1. Зөвшөөрөл эзэмшигч нь байгууламжийг аюулгүй барьж угсрах, хаягдлыг аюулгүй төлөвт байлгах, ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахуйц ашиглалтын хязгаарлалт болон нөхцөлүүдийг тогтоож, баримтжуулна.

17. Ашиглалт (үүнд туршилтын үйлдвэрлэл мөн хамаарна)

17.1. Зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын үе шатанд аюулгүй ажиллагааг хангаж, аюулгүй ажиллагааны хөтөлбөрт тусгасан ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагааны чиг үүргийг тогтоож, хадгалахын тулд зөвшөөрөл болон холбогдох дүрэм журмын шаардлагад заасан нөхцөлүүдийн дагуу байгууламжийг ажиллуулах болон туршилтын үйлдвэрлэлийг явуулна

17.2. Зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын үед үүсч болзошгүй тохиолдлууд болон болзошгүй ослын тохиолдлуудыг илрүүлж, хариу арга хэмжээ авах зохицуулалт бий болгож, хэрэгжүүлнэ. Тэдгээр нь ашиглалтын болон ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагаанд үл зөвшөөрөгдөх нөлөөлөл үзүүлэхгүй байх ёстой.

17.3. Зөвшөөрөл эзэмшигч нь байгууламжийн аюулгүй байдлыг хангах, ураны хүдрийн баяжмал алдагдах болон ураны хүдрийн баяжмалыг зөвшөөрөлгүй авахаас сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

17.4. Зөвшөөрөл эзэмшигч нь дараах зүйлсийг үнэлэхийн тулд ашиглалтын явцад мэдээлэл цуглуулах ба үүний тулд мониторинг, тандалт судалгааг эхлүүлж, үргэлжлүүлнэ. Үүнд:

- хүн ам, гадаад орчны шарлага,
- тухайн орчны бодит шинж чанар,
- тухайн орчны байгууламжид үзүүлэх хариу үйлдэл;

17.5. Зөвшөөрөл эзэмшигч нь байгууламжийг аюулгүй ажиллуулах, ашиглалтын явцад байгууламжийг аюулгүй байдалд байлгах, ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагааны шаардлагуудыг хангах ашиглалтын хязгаарлалт болон нөхцөлүүдийг тогтоож, баримтжуулж, хэрэгжүүлнэ.

17.6. Зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын үе шат эхлэхээс өмнө ашиглалтаас гаргах болон ашиглалтаас гаргасны дараах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хянуулна.

17.7. Байгууламж, ашиглалтын хязгаарлалт ба нөхцөлүүд, ашиглалтын горим болон аргачлалын ямар нэгэн өөрчлөлтийг төлөвлөж, үнэлж, баримтжуулж, хэрэгжүүлэхдээ тухайн өөрчлөлтийн аюулгүй байдлын ач холбогдолд нийцэх зохицуулалтуудыг ашиглах бөгөөд эдгээр зохицуулалт нь тухайн өөрчлөлтүүд ашиглалтын болон ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагаанд үл зөвшөөрөгдөх нөлөөлөл үзүүлэхгүй байх нөхцлийг хангах ёстой. Байгууламж

болон түүний ажиллагаанд аливаа томоохон өөрчлөлт оруулахад зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах ёстой.

18. Байгууламжийн ашиглалтын үеийн туршлага ба санал хүсэлт

18.1. Зөвшөөрөл эзэмшигч нь удирдлагын тогтолцооныхоо хүрээнд зөвшөөрөл дуусгавар болох хүртэл хугацаанд байгууламжийн бүтээн байгуулалт болон ашиглалтын бүх үе шатны аюулгүй ажиллагаанд чухал ач холбогдолтой туршлагыг системтэй цуглуулж, шүүж, шинжилж, баримтжуулахын тулд туршлага солилцох хөтөлбөр бий болгож, баримтжуулж, нэмэлт өөрчлөлт оруулж, хэрэгжүүлнэ.

18.2. Энэ хөтөлбөр нь ашиглалтын болон ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагаанд хоёуланд нь чухал асуудлыг хамарна. Энэ мэдээллийг аюулгүй ажиллагаанд сөрөг нөлөөлөх үйл явдал болон үйлдлээс сэргийлэхэд, мөн барилга угсралтын зураг төсөл буюу хэв маяг, шаардлагатай бол байгууламжийн ажиллагааг сайжруулахад хэрэглэх ёстой.

19. Тайлагнах

19.1. Зөвшөөрөл эзэмшигч нь хяналтын байгууллагад өнгөрсөн жилийн байгууламжийн үйл ажиллагааны тайланг тухайн жилийнхээ гуравдугаар сар дуусахаас өмнө гаргаж өгөх ёстой бөгөөд тайландаа дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- Байгаль орчинд цацраг идэвхт хаягдал хаягдах,
- Байгаль орчин ба хаягдлын эх үүсвэрийн хяналтын үр дүн,
- Ажиллах орчны цацраг идэвхт бохирдол,
- Ажилчид болон олон нийтийн авсан тун,
- Ураны хүдрийн баяжмалын үйлдвэрлэл болон хэлцэл, шилжүүлэг
- Үйлдвэрлэлээс гарсан, менежмент хийгдсэн, цуглуулсан цацраг идэвхт хаягдал,
- Байгууламжид оруулсан өөрчлөлт

19.2. Зөвшөөрөл эзэмшигч нь ослын үед цацрагийн аюулгүй ажиллагаанд гарсан осол болон түүний тохиолдлууд, мөн цацраг идэвхт ашигт малтмалын хүдрийн баяжмал алдагдсан болон хулгайлагдсан талаар Цөмийн энергийн тухай хуулийн дагуу эрх бүхий байгууллагад, түүнчлэн хуулинд заасан бол бусад эрх бүхий байгууллагад нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

20. Засвар үйлчилгээ ба туршилт

20.1. Зөвшөөрөл эзэмшигч нь барилга байгууламж, систем, бүрэлдэхүүн хэсгүүд ашиглалтын болон ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу ажиллах боломжтой болохыг нягтлах, баталгаажуулах үүднээс бичмэл заавар дээр суурилан засвар үйлчилгээ, давтамжит туршилт, үзлэг шалгалтын хөтөлбөр бий болгож, баримтжуулж, хэрэгжүүлнэ.

20.2. Зөвшөөрөл эзэмшигч нь аюулгүй ажиллагаанд чухал ач холбогдолтой засвар үйлчилгээ, давтамжит туршилт, үзлэг шалгалтын үр дүнг бүртгэж, үнэлгээ өгнө. Эдгээр үр дүнг ашиглан байгууламжийн загвар, барилга угсралт, ашиглалтын шаардлага хангаж буй эсэхийг хянаж, ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагаанд үзүүлэх аливаа нөлөөллийг нь тогтооно.

20.3. Туршлагаас олж авсан сургамжтай нэгтгэхийн тулд засвар үйлчилгээ, давтамжит туршилт, үзлэг шалгалтын хөтөлбөрийг тогтмол хугацаанд хянаж, шаардлагатай бол нэмэлт өөрчлөлт оруулах ёстой.

21. Ослын бэлэн байдал

21.1. Зөвшөөрөл эзэмшигч нь ажилчид болон хүн амыг хамгаалах зорилгоор гарч болзошгүй ослын эсрэг хариу арга хэмжээ авах талаар ажлын талбай дээрх ослын үеийн төлөвлөгөө бэлтгэж [хэрэв зөвшөөрөл олгогдоогүй байгаа бол зөвшөөрөл хүсэгч], баримтжуулж, хэрэгжүүлнэ.

21.2. Энэхүү ослын үеийн төлөвлөгөө нь болзошгүй ослын үр дагавартай шууд хамааралтай байх бөгөөд дараах арга хэмжээг тусгана. Үүнд:

- Ослын үед байгууламжийн үйл ажиллагааг хэвийн болгох,
- Ослоос шалтгаалан бий болох бусад үр дагавраас сэргийлэх буюу бууруулах;

21.3. Зөвшөөрөл эзэмшигч нь ослын үеийн төлөвлөлт хийх зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үүрэг хариуцлага, эрх мэдлийг тодорхой хуваарилсан зохион байгуулалт, бүтцийг бий болгож, хэрэгжүүлэх,
- Ажлын талбай дээрх ослын үеийн төлөвлөгөөн дээр үндэслэн ослын үед голомтод ажиллагчдыг хянахад шаардагдах мэргэшсэн боловсон хүчин, тоног төхөөрөмжийг шаардлагатай үед бэлэн байлгах,
- Зөвшөөрөл эзэмшигч ажлын талбайн гаднах ослын үеийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх талаар мэдээлэл, тайлбар, тодруулга өгөх,
- Ослын үеийн бүх үе шатанд ослын үеийн ажиллагааг зохион байгуулах, ослын үед хариу арга хэмжээ авах гадны байгууллагуудтай хамтран ажиллах зэрэгт шаардлагатай зохицуулалтыг бий болгох ёстой;

Зөвшөөрөл эзэмшигч нь тогтмол хугацаанд ослын үеийн дасгал сургуулилт хийх бөгөөд зарим дасгал сургуулилт дээр эрх бүхий байгууллагын төлөөлөгчийг байлцуулна. Эдгээр дасгал сургуулилтын заримд шаардлагатай бол ослын үед хариу арга хэмжээ авах гадны байгууллагуудаас оролцуулна. Ажлын талбай дээрх хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг олж авсан туршлага дээрээ үндэслэн хянаж, шинэчилж байх ёстой.

21.4. Ослын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахад “Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт, боловсруулалтын үед ослоос сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах зөвлөмж”-ийг ашиглана.

22. Хаалт буюу ашиглалтаас гаргах

22.1. Зөвшөөрөл эзэмшигч нь байгууламжийг ашиглалтаас гаргасны дараа шаардагдах аюулгүй ажиллагааны чиг үүргээ хэрэгжүүлж байхаар зохицуулж ашиглалтаас гаргана.

22.2. Зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтаас гаргасны дараа үүсч болох нөхцөл байдлыг урьдчилан тооцож байгууламжийг ашиглалтаас гаргах зураг төслийн үндэслэлийг тогтоож, баримтжуулна.

22.3. Зөвшөөрөл эзэмшигч нь зураг төслийн үе шатанд байгууламжийг ашиглалтаас гаргах ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, баримтжуулж, үйлдвэрлэл эхлэхээс өмнө болон ашиглалтын явцад гурван жилийн хугацаатайгаар эсвэл ажлын талбайн нөхцөл буюу байгууламж мэдэгдэхүйц өөрчлөгдсөн эсвэл хууль эрх зүйн шаардлагад мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан тохиолдолд илүү ойр давтамжтайгаар хянах бөгөөд ашиглалт дуусахаас дор хаяж 5 жилийн өмнө эрх бүхий хяналтын байгууллагад илгээж эцсийн төлөвлөгөөг хянуулан батлуулна.

22.4. Зөвшөөрөл эзэмшигч нь байгууламжийг ашиглалтаас гаргах дээр дурдсан төлөвлөгөөнүүдэд дараах зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

- Ажлын талбай болон үйл ажиллагааны тухай тайлбар (ажлын талбайн тодорхойлолт)
- Зөвшөөрөл ба хууль, эрх зүйн үндэслэл
- Сонирхогч талын оролцоо
- Эцсийн төлөв байдал, ашиглалтаас гаргах зорилт, ашиглалтын дараах гэсэн нэр томъёоны тодорхойлолт
- Шаардлагатай эцсийн төлөв байдалд хүрэхийн тулд харгалзан үзсэн хувилбарууд
- Ашиглалтаас гаргах үеийн үйл ажиллагааны төлөвлөгөө
- Зэрэгцэн нөхөн сэргээлтийн арга хэмжээ
- Хугацаанаас өмнө ашиглалтаас гаргах заалт
- Туршилт, судалгаа
- Ашиглалтаас гаргах үеийн болон ашиглалтаас гаргасны дараах мониторинг, тандалт судалгаа
- Зөвшөөрлөөс татгалзах ба зөвшөөрөл дуусгавар болох
- Ашиглалтаас гаргасны дараах ажиллагаа
- Ашиглалтаас гаргах үеийн ба ашиглалтаас гаргасны дараах зардлын тооцоо
- Төсөөлөл ба тодорхойгүй байдлын хураангуй

22.5. *Зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтаас гаргах ерөнхий болон эцсийн төлөвлөгөөг боловсруулахдаа “Хаалтын ерөнхий ба эцсийн төлөвлөгөө болон өртгийн тооцоо боловсруулах зөвлөмж”-ийг ашиглана.*

22.6. Зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтаас гаргах явцад аюулгүй ажиллагааг хангаж, аюулгүй ажиллагааны хөтөлбөрт заасан ашиглалтаас гаргасны дараах аюулгүй ажиллагааны чиг үүргийг тогтоож, хадгалахын тулд ашиглалтаас гаргах эцсийн төлөвлөгөөний дагуу ашиглалтаас гаргах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

22.7. Зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтаас гаргах үйл ажиллагаа, аргачлалын ямар нэгэн өөрчлөлтийг төлөвлөж, үнэлж, баримтжуулж, хэрэгжүүлэхдээ тухайн өөрчлөлтийн аюулгүй ажиллагааны ач холбогдолд нийцэх зохицуулалтуудыг ашиглана.

22.8. Ашиглалт болон ашиглалтаас гаргасны дараах цацрагийн аюулгүй байдалд нөлөөлөх аливаа томоохон өөрчлөлтийг ашиглалтаас гаргах арга хэмжээнд оруулахдаа зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах ёстой.

23. Ашиглалтаас гаргасны дараах үе шат ба хяналтаас чөлөөлөгдөх

23.1. Зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтаас гаргасны дараа болон зөвшөөрөл дуусгавар болтол ашиглалтаас гаргасны дараах мониторинг болон тандалт судалгааны хөтөлбөр хэрэгжүүлэх ёстой.

23.2. Тухайн мониторинг буюу тандалт судалгаагаар нөхөн сэргээх арга хэмжээ авах шаардлагатай болох нь тогтоогдвол зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрөлд заасны дагуу тус арга хэмжээг хэрэгжүүлнэ.

23.3. Зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийг дуусгавар болгохын тулд аливаа мониторинг, тандалт судалгааны хөтөлбөрийн үр дүнг аюулгүй ажиллагааны хөтөлбөрийн агуулгатай нийцэж байгааг эрх бүхий байгууллагад хангалттай түвшинд нотлох, газар ашиглалтад хязгаарлалт тавихыг санал болгох, энэ арга хэмжээг буюу зөвшөөрлөөс хойших үе шатанд тохиромжтой гэж үзсэн бусад арга хэмжээг хэрэгжүүлэх арга замыг санал болгож, үндэслэл гаргах ёстой.